

КОНЦЛАГЕРЫН ХОРИГДЛУУДЫН ЭКЗИСТЕНЦИЙН ТУХАЙ Х.АРЕНДТЫН ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ

Ж.Жаргал – МУИС-ийн магистрант

Түлхүүр үг: бөөнөөр хорих лагерь (концлагерь), хоригдол, золиос, экзистенц, “Би”, хүнийсэл, тусгаарлал, зовлон, айдас, тамлал, үхэл, эрх, эрх чөлөө

Товч утга: Энэхүү өгүүлэлд тоталитаризм, түүний үйлдсэн гэмт хэрэг, тухайлбал бөөнөөр хорих лагериуд дахь хоригдолуудын экзистенцийн талаархи Х.Арендтын үзэл санааг улс төрийн философийн аспектээр авч үзэхийг оролдсон болно.

Улс төрийн тоталитар дэглэм XX зуунд дэлхийн арав гаруй оронд тухайн үеийн түүхэн нөхцөл байдал, тодорхой шалтгаан, холбогдох хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсэн тогтож, тэдгээр орны нийгэм, хүн ардын амьдралд гашуун зовлон учруулж, “бэртэл”, “сорви” үлдээсэн билээ.

Түүнийг судлан шинжлэхэд Ханна Арент (1906-1975) жинтэй хувь нэмэр оруулсан байна. Тэрбээр Рудольф Бультман, Эдмунд Гуссерль, Мартин Хайдеггер, Карл Ясперс нарын лекцийг сонсож оюун сэтгэлгээ нь төлөвшин хөгжсөн, тэдний дотны шавь нь байсан бөгөөд хожим XX зууны Герман, Америкийн улс төрийн сэтгэлгээ, улс төрийн философийн сонгодог төлөөлөгч болж алдаршжээ. Х.Арендтын гол бүтээл бол “The origins of totalitarianism” буюу “Тоталитаризмын эх үүсвэр” хэмээх бүтээл мөн болно. Судлагч эрдэмтэд эл зохиолыг 1940-өөс 1950-иад онд Өрнөдөд тоталитаризмын асуудлаар гарсан цөөн тооны сонгодог, суурь бүтээлийн нэг мөн гэж үздэг байна. Х. Арент эл зохиолдоо тоталитаризм үүсэх үзэл санаа, нийгэм-эдийн засаг, улс төрийн урьдач нөхцөл, үндэс суурь хийгээд тэдгээрт тулгуурлаж тоталитар дэглэм тогтож ноёрхсон асуудлыг бусад эрдэмтэдтэй харьцуулахад хамгийн дэлгэрэнгүй, олон талаас нь авч үзсэн учираас тоталитаризмын тухай түүний үзэл баримтлал нэн цэгцтэй, бүхэл, өргөн агуулгатай болсон байна.

Х.Арендтын онолын үзэл баримтлал ёсоор тоталитаризм XIX зуунаар бэлтгэгдэж, XX зууны эхээр илэрэн гарсан Европын орнуудын нийгмийн амьдралын “хүнд бэртэл” бүхий хямралаас төрж бий болсон бөгөөд уг хямралын тод шинж тэмдэг, бас эл хямралаас гарах гарц бүхий арга замыг заасан үзэл суртлын логик конструкции, түүнийг амьдралд хэрэгжүүлэх практик болж үүсэн гарсан XX зууны цоо шинэ, нарийн нийлмэл үзэгдэл ажээ (6,597).

Х.Арендтын зохиолын “Тоталитаризм” хэмээх гуравдугаар хэсэг (анги) бол тоталитаризм үүсэж бүрэлдсэн, тогтож ноёрхсон үйл явц, арга хэрэгсэл хийгээд эл дэглэмийн мөн чанар, бүрэлдэхүүний хэсэг, гол шинжүүдийн тухай асуудлыг шинжлэн авч үзсэн, тиймээс ч нэн сонирхолтой, гүнзгий утга санааг агуулсан гол хэсэг болно. Эл хэсэгт Х.Арендт нийгмийг бүхэлд нь хамарсан террор, тэр дотор бөөнөөр хорих лагериудын зориулалт, үүрэг, тэдгээр дэх гэмгүй үй олон хоригдолуудын экзистенци, зовлон, тамлал, үхэлийн асуудлыг философийн аспектээр, чухамдаа экзистенциалист философийн үзэл санаагаар авч үзэж илэрхийлэн гаргажээ. Энэ нь Х.Арендт өөрөө философч, тэгэхдээ К.Ясперс, М.Хайдеггер нарын шавь байж, тэдний экзистенциалист философийн үзэл санаатай ойр дотно байж танилцсан, нөлөөг нь тодорхой хэмжээгээр тусгаж байсантай холбоотой.

Тоталитар дэглэм, тоталитар төр оршин тогтож ноёрхох хамгийн гол хэрэгсэл, арга бол бүхнийг хамарсан, түгээмэл чанартай хүчирхийлэл, чухамдаа террор буюу хүн амыг үй олноор нь хорьж цагдах, алж хядах замаар нийгмийг байнгын айдас түгшүүртэй байлгаж дарангуйлах явдал бөгөөд тиймээс бүхнийг хамарсан террор (тотальный террор) бол тоталитаризмын мөн чанар (6,615), хүний эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэх нь тоталитаризмын мэргэжил мөн болно гэж Х.Арендт заажээ (6, 399).

Энэхүү үзэл санаа тоталитаризмын тухай Х.Арендтын үзэл баримтлал нь бусад онолоос ялгагдах онцлог нь юм. Ингэж хэлэхийн учир нь тоталитаризмын онолыг боловсруулахад жинтэй хувь нэмэр оруулсан бусад томоохон эрдэмтэд террор бол тоталитаризмын нэн чухал, үндсэн шинжүүдийн нэг мөн болохыг санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг боловч түүнийг эл дэглэмийн мөн чанар гэж тэр бүр үздэггүй билээ. Тиймээс тоталитаризмын тухай Х.Арендтын үзэл баримтлалыг ул үндэстэй судлах, ухааран ойлгохын тулд террор, концлагерын талаархи түүний үзэл санааг анхааралтай авч үзвэл зохино.

Х.Арендт бүхнийг хамарсан террорыг тоталитаризмын мөн чанар гэж үзсэн явдал нь нэг талаар тэрбээр эл дэглэмийг сонгодог бөгөөд хамгийн хахир хатуу хэлбэрээр тогтон ноёрхож, сая саяаар тоологдох хүн ардыг бөөнөөр хорьж, алан хядсан Германы фашизмын жишээ баримтыг голлон түшиж авч үзсэнтэй, нөгөөтөйгүүр сэтгэгч өөрөө эл оронд төрж өссөн, фашизм, антисемитизмын хор уршигийг биеэрээ амссан еврей хүн, түүнчлэн үзэл санаа, нийгмийн байр суурь нь тоталитаризмыг үзэн ядах, бас судлан танин мэдэх явцад төлөвшин тогтсонтой холбоотой гэж үзэж болно. Хамгийн гол нь Х.Арендт зохиолоо Германы фашист тоталитар төрөөс бөөнөөр хорих лагериудад үйлдсэн аймшигт аллага, гэмт хэргийн халуун мөрөөр, тэдгээрийн үлдээсэн айдас түгшүүр, сэтгэл зүйн гүн шарх хүмүүсийн санаа сэтгэл, ой ухаан, оршихуй буюу экзистенцэд шинэ, хурц хэвээрээ байсан дэлхийн II дайны дараахан бичиж эхлэн, 1949 онд дуусгасантай шууд холбоотой юм.

Тоталитаризм хэвийн амьдралтай, тогтвортой нийгэмд биш, харин нэг талаар нийгмийн социал хүрээ, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдрал нь “бэртсэн”, хямралтай нөхцөлд, нөгөөтэйгүүр тийм нөхцөл байдлын төрүүлж бий болгосон “хүний материалаар” бий болж босдог, өөрөөр хэлбэл өөрт нь тохиромжтой нийгмийн бааз суурин дээр үндэслэж үүсдэг ажээ. Тэрхүү бааз суурь буюу “хүний материал” нь масс (mass - масса) буюу олон түмэн юм. Тоталитар төр концлагерийн хоригдолууд, олон сая “золиос”-ыг чухамдаа массын дотроос дур зоргоор олж, хилс яллана.

Х.Арендт тоталитар дэглэмийн нийгмийн бааз болох массыг бүрдүүлдэг бодгалууд буюу “массын хүн” (mass human – массовой человек) хийгээд хорих лагериуд дахь хоригдолуудын оршихуй, “Би”-гийн ахуйг авч үзэхдээ экзистенциалист философид хэрэглэдэг “Би”, түгшүүр, зовуурь, аймшиг, айдас, зовнил, жигших, хүнийсэх, орхигдох, хаягдах, утга учиргүй, хариуцлага, сонголт, үхэл, зовлон, тусгаарлал, саланги байхуй, арга ядах, хүчгүйдэх, ганцаардал, аглаг байхуй гэсэн ойлголт, нэр томъёог хэрэглэжээ. Сэтгэгч бээр тэдгээрийн дотроос ганцаардал (одиночество), ганцаар буюу аглаг байхуй (уединение), тусгаарлал (изоляция) гэсэн ойлголтуудын утга санааг тусгайлан авч үзэж тайлбарлаад тэдгээрийг “тоталитар бие хүн”, “массын хүн” –ий оршихуй, нийгэм–улс төр, сэтгэл зүйн шинж чанарыг судлахад чухалчлан хэрэглэжээ.

Х.Арендт, нэгдэл нягтралтай, хамтын амьдралтай хүмүүсийг тоталитарист террорын арга хэрэгсэлээр удирдан засаглах, ноёрхох аргагүй, харин чухам хоорондоо тусгаарласан, саланги, тасархай хүмүүсийг л санаснаар удирдах, дарангуйлах бүрэн боломжтой, учир нь тийм хүмүүс хүчгүйдсэн, арга ядсан байдаг, тиймээс дарангуй засаг хүмүүсийг хооронд нь хагаралдуулж тусгаарлахыг нэн тэргүүний зорилтоо болгодог, харин хүмүүсийн эв нэгдэл, нягтрал, хамтын амьдралаас дарангуйлалыг эсэргүүцэх нийгмийн хүч энерги ундрал гардаг гэж дурджээ (6, 615 – 616).

“Хүмүүс хоорондоо тусгаарласан, тэгээд ч хүчгүй, арга ядсан байх явдал буюу хөдөлж үйлдэх чадваргүй болох нь эзэрхэг засгийн шинж чанар ямагт байсаар иржээ (6, 616). Улс төрийн хүрээнд тусгаарлал гэж бидний нэрлэдэг зүйл маань хүмүүсийн хоорондын харилцааны хүрээнд ганцаардал гэж нэрлэгддэг бөлгөө. Тусгаарлал ба ганцаардал хоёр адил зүйл бишээ. Тухайлбал, би ганцаараа биш хирнээ тусгаарлагдсан байж болно; би бас тусгаарлагдаагүй хирнээ ганцаардсан байж болно. Тусгаарлал бол хүмүүсийн амьдрал илэрэх, тэд нийтлэг эрх ашгийн дагуу хамтдаа хөдлөж үйлдэх улс төрийн хүрээ эвдрэхэд тэднийг хөөж оруулах мухар юм” гэж Х.Арендт бичжээ (6, 616).

“Экзистенцлэг ганцаардал нь ганцаар байх, аглаг амьдрах явдал биш юм. Ганцаар, аглаг байхын тулд ердөө ганц биеэрээ аж төрөх явдал хүрэлцээтэй байдаг бол

ганцаардал нь хүн бусад хүмүүсийн дунд, нийгэмд аж төрөхөд хурц илэрдэг байж болно. Бусад хүмүүсийн хүрээлэлд аж төрж буй хирнээ тэдний хэнтэй нь ч харилцаж чадахгүй, эсвэл тэдгээрийн хэн нэгний өшөөрхөлийн өмнө хүчгүй, хамгаалалтгүй байгаа хүн бол ганцаардсан хүн мөн. Харин бусдын хүрээллийн гадна байгаа хүн бол ганцаар, аглаг сууж буй хүн мөн бөгөөд тиймээс ч тэрбээр “зөвхөн өөрөө өөртэйгээ л хамт байж чадна”. Өөрөөр хэлбэл, би бээр ганцаар аглаг байхуйд өөрөө “өөрийн хүсэл зоригтойгоо” хамт, өөрийн “Би” – тэйгээ хамт байх бөгөөд тэгснээрээ өөрийн ганц биендээ хоёулаа байгаа мэт байна. Гэтэл ганцаардсан байгаа минь би бээр үнэхээр ганц, бусдад орхигдсон, хаягдсан хэрэг юм (6, 618). ... Гэхдээ ганцаар, аглаг байхуй нь ганцаардал болж хувирч болно, энэ нь тухайн хүнийг “Би” нь орхисон тохиолдолд үүснэ. Хүнийг “Би” нь орхих явдал ганцаардлыг тэсхүеэ бэрх болгоно... Хүн “Би” – гээ алдснаар өөрөө өөртөө, өөрийн дотоод ярилцагчдаа итгэж найдах итгэл найдвараа алдана” (6, 619).

“Энгүүндээ өтөл нас гэх зэрэг нийгмийн маргинал нөхцөлд харьцангуй цөөн хүмүүсийн хэтийдсэн туршлага болж байсан ганцаардал нь тоо хэмжээ нь улам бүр өсөн нэмэгдэх массын өдөр тутмын туршлага болж хувирсан тэрхүү баримт нь тоталитар биш нийгэм дэх хүнийг тоталитар ноёрхолд зориулж бэлтгэдэг ажээ (6, 620). Тоталитаризм хүмүүсийн хоорондын аливаа эрх чөлөөт орон зайг эвдэн бусниулж, хүмүүсийг нэгийг нөгөөгөөр нь хүчирхийлэн дарж, тэдний бүтээлч хүч бололцоог устгадаг” (6, 621). Х.Арендт тийнхүү хүний амьдрал, оршихуйн зовлонтой, хурц, бэрх төлөв байдал бүхий өвөрмөц туршлага болох ганцаардал, ганцаар аглаг байхуй, тусгаарлалын талаархи дээр дурдсан философи үзлээ тоталитаризмын нөхцөл дэх “массын хүн”, бөөнөөр хорих лагериуд дахь хоригдолуудын экзистенцийг авч үзэж тайлбарлах, ойлгоход үзэл санаа, бодол эрэгцүүллийн ерөнхий суурь дэвсгэр болгон баримталжээ.

Тоталитаризм өөрийн зохион байгуулалт, оршин тогтнол, ноёрхлын арга хэрэгсэлээ улс төрийн дарангуй дэглэмийн тиран, деспотизм, диктатур гэсэн уламжлалт хэлбэрүүдээс зээлдэн авч, тэдгээрийг “бүх юм зөвшөөрөгдсөн” гэсэн бүхнийг үгүйсгэсэн зарчмын үүднээс боловсронгуй, төгөлдөр болгожээ (6, 572). Тэгэхдээ тоталитаризм дээрхи дарангуй дэглэмүүдээс үндсээрээ, эрс ялгаатай ажээ. Тухайлбал хууль ёсыг баримтлах нь дарангуй бус дэглэмийн мөн чанар, хууль ёсгүй явдал нь дарангуй дэглэмийн мөн чанар байдаг бол иргэдийг хууль бусаар дур зоргоор хорьж, алж хядах явдал буюу террор нь тоталитаризмын мөн чанар, онцлог шинж юм хэмээн Х.Арендт онцлон заажээ (6, 597-603). Тэрбээр, “... аливаа хэлбэрийн авторитаризм нь эрх чөлөөг ямагт шахан хавчдаг, аль эсвэл хязгаарлаж байдаг боловч хэзээ ч халж устгадаггүй. Харин тоталитар ноёрхол нь эрх чөлөөг халж устгах, түүгээр ч үл барам ер нь хүний өөрт нь аяндаа бий болдог чанарыг (спонтанность) устгахад чиглэсэн байдаг” гэж бичжээ (6, 528). Түүний эл үзэл санаа улс төрийн ардчилсан бус дэглэмүүд ба тэдгээрийн түүхэн тодорхой хэлбэрүүдийг хооронд нь ялган авч үзэж судлахад арга зүйн ач холбогдолтой байгаа болно.

Тоталитаризм цаашид хүчирхэгжиж ноёрхох явцад түүний баримталдаг “бүх юм зөвшөөрөгдсөн” гэсэн зарчим нь хэмжээнээсээ халин гарч “бүх юм боломжтой” гэсэн урьд өмнө байгаагүй цоо шинэ зарчим болж хувиран хэрэгжих болжээ (6, 572). Эл зарчим ямар нэгэн ашиг олз хайсан утилитар, прагматик санаа сэдэлээс ангид ажээ. Түүний дагуу тоталитар дэглэм өөрөө өөртөө зорилго болсон тоталитар үзэл суртлыг удирдлага болгож тогтон ноёрхсон байна. Энэ нь хийсвэр, санаалаг зүйл болох тоталитаризмын үзэл сурталд нийгмийн бодит амьдрал, түүний тодорхой олон талтай, олон янз байдалтай үзэгдэл, үйл явцыг хүчээр захируулж нэгэн нэгдмэл төлөв байдалтай болгож хэвшүүлэн цутгахыг шаарджээ. Үүнд хамгийн түрүүнд саад болсон зүйл бол хүмүүсийн эрх, эрх чөлөө, түүнчлэн тэдний амьдрал, эрх ашиг, нийгмийн байр суурь, үзэл санаа, итгэл үнэмшил, үнэлэмж, эрхэмлэл нь олон янз байдаг явдал байв. Тиймээс тоталитаризм нэн түрүүнд хүний эрх, эрх чөлөө, амьдралын олон янз байдлыг хүчирхийлэн арилгаж устгах, нийт хүмүүсийг нэгдмэл **Нэг хүн** болгож хувиргахыг хамгийн гол, тэргүүн зэргийн зорилго болгосон байна. Энэ нь хүнийг хүчэрхийллээр

дахин төрүүлж хувиргана гэсэн үг. "Тиймээс тоталитар үзэл суртлын зорилго нь гадаад ертөнцийг өөрчлөн засах, нийгмийг хувьсгалт ёсоор өөрчлөн хувиргах явдлын аль нь ч биш, харин хүний уг чанарыг дахин төрүүлж хувиргахад оршино. Бөөнөөр хорих лагериуд нь хүний уг чанарын өөрчлөлтийг хянаж мөшгих, бас туршиж шалгах лаборатори мөн болно" (6,594).

Тоталитаризмын хүчирхийлэл дахин төрж хувирсан Нэг хүний хамаг хэрэг зориг, бүхий л үйл ажиллагаа нь **Байгаль** ба **Түүх** хоёрын санаа зорилгыг хэрэгжүүлэх, хөдөлгөөнийг нь хурдасгахад оршино. Өөрөөр хэлбэл, хүн, хүн төрлөхтөн бол Байгаль, Түүхийн зорилго, хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хэрэгсэл, нэг ёсондоо "түүхий эд" нь юм (6,605).

Х.Арендт зохиолдоо Байгаль, Түүх гэсэн ойлголтыг тоталитаризм ба түүний Германд тогтсон нацист хэлбэр, ЗХУ-д тогтсон коммунист хэлбэрийг илэрхийлэн тэмдэглэж хэрэглэсэн байна. Нацист тоталитар үзэл суртал ёсоор ари угсаатан бол дэлхийн нийт арьстан, угсаатны хамгийн шилдэг, эрхэм дээд нь бөгөөд харин германчууд тэрхүү ари угсаатны оройн титэм, сор нь ажээ. Тийнхүү герман үндэстэн нь амьдрал, амьд амьтан, түүний оройн титэм болж төрөн гарсан хүн, хүн төрөлхтөнийг төрүүлсэн Байгалын хувьсалын зорилго, чиглэлийг илэрхийлэн хэрэгжүүлэгч, Байгалаар шилэгдсэн үндэстэн болно. Тиймээс Германд нацист тоталитаризм тогтож ноёрхсон явдал бол Байгалын хуулийн үйлчлэлийн илэрэл, харин нацистууд концлагериудад бусад үндэстэн угсаатаны хүмүүсийг хэдэн арван саяаар нь алж устгасан явдал бол "амьдралд зохицон идээших чадваргүй", амьдралын хаягдал бүхий сул дорой арьстан угсаатан, хувь хүмүүст Байгалаас жам ёсоор оноосон цаазаар аваачих ял ажээ (6,605).

Тухайн үеийн ЗХУ-д тогтсон коммунист тоталитаризмын үзэл суртал ёсоор коммунизм, тухайлбал ЗХУ-д байгуулагдах коммунист нийгэм нь Түүх буюу нийт хүн төрөлхтөний түүхэн хөгжил, хөдөлгөөний оргил, эцсийн төгс төгөлдөр шат бөгөөд зөвлөлт төр олон сая хүнийг "ардын дайсан" хэмээн хэлмэгдүүлсэн, бөөнөөр хорих лагериудад (ГУЛАГ) хороосон явдал нь Түүхийн хаягдал буюу нийгмийн "үеэ өнгөрүүлсэн", "мөхөх тавилантай" анги давхраанд Түүхээс зүй ёсоор оноосон цаазаар аваачих ял байсан ажээ (6,605).

Х.Арендт тоталитаризмын уг шинж, мөн чанарын тухай өөрийн үзэл санааны ийм дэвсгэр суурин дээр тоталитар террор, түүнийг үйлдэх гол талбар, байр сав болох концлагер ба түүн дэх хоригдолуудын экзистенци, тамлал, үхэлийг бодрол ухааны гүнээр, сэтгэлийн нарийн хурц, соргог мэдрэмжээр шинжлэн авч үзсэн байна. Одоо тэр талаар өгүүлье.

Х. Арендт зохиолдоо бөөнөөр хорих лагерь, түүнд гэмгүй хүмүүсийг үй олноор нь хорьж, алж устгаж байсан террорын үйл ажиллагааг зөвхөн нийгэм-улс төр, хууль-эрх зүйн талаас нь төдийгүй нийгмийн сэтгэл судлал, экзистенциалист философийн үүднээс авч үзжээ. Тэрбээр тоталитар дэглэмийн байгуулсан бөөнөөр хорих хийгээд алж устгах лагериуд нь "бүхнийг хийх боломжтой" гэсэн тоталитаризмын суурь шинжтэй үзэл санаа, итгэл үнэмшлийг амьдралд нягтлан шалгах, нотлож батлах туршилтын лаборатори, тоталитар төрийн хамгийн чухал, төв байгууллага мөн болно гэжээ (6,568-569).

"Үхлийн фабрик" гэж нэрлэгдэж байсан бөөнөөр хорьж устгах лагерь, түүнд үйлдэгдэж байсан террор буюу аллага бол тоталитаризмын мөн чанар ажээ. Учир нь тоталитар дэглэм тогтсон улс орны хүн амыг бүхэлд нь тоталитар төрийн нэгдмэл нэгэн ноёрхол, хараа хяналтад байлгаж засаглахын тулд тус бүртээ байгалаас заяасан давтагдашгүй өвөрмөц бодгаллаг шинжтэй хувь хүмүүсийг зөвхөн хүчирхийлэл, бөөнөөр хорьж устгах лагерийн тусламжаар л нэгэн ижил, нэг төлөв байдалтай болгож болно. Лагериудад үйлдэгдэж байсан тамлал, аллагыг жирийн амьдралын туршлагаар төсөөлөн ойлгох аргагүй, тэр бол огт өөр ертөнц байжээ. Түүгээр ч үл барам концлагериудыг энгийн шорон, түүн дэх албадлагын хөдөлмөр, дэглэх явдалтай ч харьцуулан төсөөлж ойлгох аргагүй ажээ. Учир нь энгийн хорих газрын хоригдол нь шударга шүүхээр яллагдсан, ял эдлэх хугацаа нь тодорхой, хамгийн гол нь өөрөө

өөрийн биедээ эзэн, туйлын ноёрхол, туйлын тамлалгүй байдаг” гэж Х.Арендт бичжээ (6,576).

Хорих лагериудад, ер нь тоталитар дэглэмийн нөхцөлд хүмүүсийг бүрэн ноёрхохын тулд хийгддэг хамгийн эхний алхам, арга хэмжээ бол хүнийг хууль-эрх зүйн этгээд биш болгох явдал байжээ (6, 580). Үүнд нэн түрүүнд хорих лагерьт ирж буй хүмүүс аль хэдийнээ иргэний харъяалалгүй болсон, дэлхийн дайн, хувьсгал, иргэний дайны хөлд үрэгдсэн этгээд байсан явдал нөлөөлж байв. Хамгийн ноцтой нь лагериуд угаасаа хууль ёс, эрх зүйн хэвийн орчноос бүрэн тусгаарлагдсан бат бэх хэрэмий хана, хаалтын цаана байгуулагдсан учираас хоригдлууд шударга шүүхийн хууль ёсны процедурын гадна үлджээ.

Тоталитаризмын золиосууд концлагерь хэмээх тамын оронд ирэхийн өмнө амсаж эхэлдэг зовлон бол хууль бусаар баривчлагдах, ачааны вагонд малаас дор байдлаар чихүүлж ачигдан, олон тойруу чиглэлүүдээр нааш цааш удаан тойрч зөөвөрлөгдөх, лагерт ирж нэгэн ижил эрээн хувцас өмсөх, үсээ хусуулах, ариун цэврийн аюумшигтай нөхцөлийг зориуд бүрдүүлсэн байранд бөөнөөр байрлах явдал байжээ. Хоригдлуудыг концлагерьт эрүүгийн гэмт хэрэгтэнүүдтэй нэг дор байлгадаг явдал цөөнгүй байсан нь нэг талаар нацистууд концлагериудын зориулалт, үнэн байдлыг халхлах, нөгөө талаар хоригдлууд эрүүгийн гэмт хэрэгтэнүүдтэй нэг дор байгаагаа хараад хууль ёсны гадна үлдсэнээ, амьдралын ёроолд дахин гаршгүйгээр шийдэгдэж орсноо мэдэрч сэтгэл итгэл алдарахад нь нөлөөлөх давхар зорилттой байжээ.

Хорих лагериудад хүмүүсийг “амьд хүүр” болгож хувиргах хоёр дахь арга хэмжээ, алхам бол хүмүүнд байдаг, хүнийг чухам хүн болгож байдаг ёс суртахууны эх үндэсийг арилган устгах явдал байжээ. Нацистууд үүнийг лагериудын үүд хаалганд, “Энд ямар нэгэн эсэргүүцэл илэрхийлэх нь утгагүй зүйл болно гэдгийг сана!” гэсэн бичиг өлгөснөөр эхэлжээ. Хоригдлуудыг “амьд хүүр” болгоход саад болж хүмүүст үлддэг эцсийн нандин чанар бол тэдний бодгаллаг хувь шинж ажээ. Гэхдээ хүнд байдаг ёс суртахууны эх үндэс ба хүн хууль эрх зүйн этгээд байдаг чанарыг нь арилган устгасны дараа түүний бодгаллаг хувь шинжийг устгах нь хялбар бөгөөд амжилттай болдог байна (6,590).

Х. Арендт тоталитар дэглэмийн байгуулсан бөөнөөр хорьж устгах лагерь бол хүмүүсийг яс махнаас бүтсэн бие цогцостой биологийн амьтан болохын хувьд нь, бас ухамсартай, ёс суртахуунтай нийгэм-соёлын амьтан болохын хувьд нь туршилт хийж, уг шинжийг нь өөрчлөж болох эсэхийг шалгасан аюумшигтай туршилт, гэмт хэргээс хавьгүй илүү том нүгэл байсныг философийн утга агуулгаар гарган тавьжээ.

• Германы нацистууд хоригдлуудыг бөөнөөр хороохдоо өвөрмөц философийг баримталдаг байжээ. Тэр философиор хоригдлууд ерөөс хүний үнэ цэнэгүй, учир нь тэдний нэгийг нь нөгөөгөөр нь маш хялбар сольж, орлуулж болно. Тэр дагуу хоригдлуудыг, нэгдүгээрт, үг дуугүй шууд хороож устгавал зохих еврейчүүд, хоёрдугаарт, үхэлийг нь тодорхой хугацаагаар, түр хойшлуулж байвал зохих польш, орос, украинчууд, гуравдугаарт, дээрээс тушаал иртэл үхлийг нь хойшлуулбал зохих франц, бельгичүүд гэсэн ангилалд хувааж шат дараатай хороож байжээ (6,574).

Х.Арендт ЗХУ-д үүнээс өөр философи, хоригдлуудын өөр ангилал байсан нь, нэгд, харьцангуй чөлөөтэй амьдрах, тэгэхдээ ажиллах хүч байвал зохих хүмүүс бөгөөд тэднийг цаг ирэх тусам шат дараалуулж мөрдөн мөшгих, концлагерийн “түүхий эд” болгож бэлтгэх ёстой; хоёрт концлагерьт нэгэнт хоригдсон “хүн хэмээх материал” байх ба тэднийг хайр найргүй албадан хөдөлмөрлүүлж мөлжих хэрэгтэй; гуравт, үхлийн лагерьт байгаа золиосууд, тэд ерөөс орхигдсон, тэдэнд сум гарздах хэрэггүй, тэд голцуу, аяндаа өлбөрч, даарч, турж үхнэ гэсэн үзэл, хандлага байсан гэжээ (6,574). Х.Арендт тоталитаризмын нөхцөл дэх концлагериуд үндсэндээ албадан хөдөлмөрлүүлэх буюу эдийн засгийн үүрэг зорилгогүй, цэвэр улс төр, үзэл суртлын зорилготой, золиосуудыг бөөнөөр нь хороож устгах, нийгмийг байнгын айдастай, хүлцэнгүй “номой” байлгаж ноёрхох үүрэг зориулалттай байсныг гаргаж тавьсан байна (6,577).

Хүний бие махбод хэрэг дээрээ тамлалд удаан тэсэх, хязгааргүй зовох, өвдөж шаналах бололцоотой ажээ. Концлагериудад хүний бие махбодийн энэхүү тэсвэрийг

ашиглаж шат дараалуулан удаан тамлаж зовоох замаар хүний хүн чанар, ёс суртахуун, итгэл үнэмшил, эрхэмлэл, тэмүүлэл, нэг үгээр хэлбэл, оюун санааг нь эвдэж задлах, “тээрэмдэж” үгүй болгох явдлыг туршин хэрэгжүүлж байжээ. Концлагериудад хоригдлуудыг тамлан тарчилгах явдал нь эхэн үедээ мэдүүлэг авах зорилгоор хийгддэг, өөрөөр хэлбэл тодорхой үүрэг, зориулалттай байжээ. Концлагериудад удалгүй тамлалын өөр, шинэ хэв маяг, төрөл бий болсон нь ямар ч зорилго, утга учиргүй, тамлахын тулд тамлах, тамлал нь өөрөө өөртөө зорилго болж хувирсан садист тамлал нэмэгджээ (6,588). Ийм тамлалыг хэвийн биш, садист, алуурчин этгээд үйлдэж байв. Энэ нь тоталитар дэглэм садист, алуурчин этгээдүүдэд буулт хийж байсан хэрэг ажээ. Хоригдлуудыг тамлах, үй олноор нь устгах явцад хэвийн сэтгэл зүй, зан байдалтай байсан харгалзагч, тушаал гүйцэтгэгчид хэвийн биш, садист үйлдэлтэй болж хувирах явдал олонтоо тохиолдож байжээ.

Х. Арентт фашизмын хорих лагериудад хүмүүсийг төсөөлөн ойлгохын аргагүй байдлаар тамлаж, эцэст нь ихэнх тохиолдолд хорт хийн том өрөө, хонгилд бөөнөөр нь шахан оруулж алж байсан явдал бол нэг ёсондоо гэмгүй хүмүүсийн аюумшигтай, жам ёсны бус үхлийг удаашруулсан дүр зураг байсан гэжээ. Бөөнөөр хорих лагериуд дахь хоригдлуудын амьдрал, экзистенцийг түүхэнд яг бодитой байсан байдлаар нь ойлгох, сэргээн санаж тодорхойлон бичих, хүмүүст хүргэх аргагүй, учир нь хорих лагериудад чухам юу болж байсан талаар чин үнэн хийгээд хүрэлцээтэй, хангалттай ул мөр, баримт материал төдийлөн хадгалагдаж үлдээгүй, бидэнд тодорхой байгаа баримт бичиг, кино болон гэрэл зураг, яс, арьс болж амьд гарсан хоригдлуудын яриа, дурсамж зэрэг нь бодит, биет юмс өөрөө биш, харин тэдгээрийн сүүдэр мэт зүйлс л ажээ.

Тоталитар төр, түүний аюумшигтай гол хэрэгсэл болох концлагериуд эрх зүйт, шударга шүүхээр бүрэн төгс зэмлэж яллах, бас түүхийн үүднээс уучилж өршөөх, урсан өнгөрөх цагийн аясаар мартаж умартахын аргагүй, орчин цагийн соёлт хүний ой ухаанд багтаж оромгүй туйлын гэмт хэрэг байдагийг хүн төрөлхтөнд харуулж сануулсан гэж Х.Арендт тэмдэглэсэн байна (6, 595). Тоталитар төр, түүний бөөнөөр хорих лагериудын хүн төрөлхтөний өмнө үйлдсэн Туйлын гэмт хэрэг, нүгэл, ер нь нөмөрүүлсэн Том аюул нь юунд байсан вэ гэвэл тэдгээр нь хүнийг хүн биш, чухам нэг төрлийн, маш энгийн реакци бүхий үйлдэлтэй нэг ёсны амьтан болгож хувиргаж болно, Тоталитар төр “хүн хэмээх эд материал”-аар бодож санасан, зорьж оролдсоноороо юуг ч хийж болох юм байна гэдгийг туршиж нотолсонд оршино гэж Х.Арендт үзжээ.

Оросын физиологч эрдэмтэн Павловын туршилтын нохой хэрэг дээрээ хэвийн нохой биш байсан, тухайлбал уг нохой хичнээн өлссөн ч өмнө нь идэш тавьж өгөхөд хэрэв хонх дуугарахгүй бол, туршилтаар суулгасан нөхцөлт рефлексийн дагуу түүнийг иддэггүй байсан баримт нь “тоталитаризмын синдромтой бие хүн”, тоталитаризмын бий болгож чадсан бүгдээрээ нэг маягаар бодож сэтгэдэг, хийж үйлддэг “массын хүн”- ийг үзэж ойлгох аналог болно гэсэн санааг Х.Арендт хэлжээ(6, 569). Бөөнөөр хорих лагериудын сая саяар тоологдох хоригдлууд туршилтын тамлалаар байгалиас заяасан жам ёсны бодгаллаг чанараа алдаж, өөрөө өөрөөсөө няцаж, өөрийн “Би”- дээ орхигдож, эцэстээ хорт хийн үхлийн хонгил руу ямар ч эсэргүүцэл гаргахгүйгээр дуулгавартай цуван ордог болсон, ер нь лагерьт хоригдлууд амиа хорлох, босож тэмцэх, харгалзагч, хорт хийн хонгилыг хариуцсан инженер, эмч нарын хэн нэгнийг хорт хийн үхэл руу хамт авч явахыг оролддоггүй байсан зэрэг явдал бол тоталитаризм, түүний туршилтын лабортари бүхий хорих лагериуд хүнийг чухам хэн, юу болгож хувиргаж чадсны гэрч, баримт юм гэж Х.Арендт бичжээ (6, 590- 591).

Концлагериудад хоригдлуудыг хэдэн зуун мянгаар нь устгаж байсан үзэгдлийг “хүний амь хороох”, “алах”, эсвэл “үхэл” гэсэн ердийн ойлголтоор тэмдэглэн ойлгох аргагүй, хүмүүсийг нэг дор үй олноор нь устгаж, хүний хүүрийг бөөнөөр нь үйлдвэрлэж байсан нөхцөлд “аллага”, “үхэл” гэсэн ойлголт өөрийн ердийн утгаа алдана(6,574). Концлагериуд аллагыг хэдэн саяар нь үйлдээд зогсохгүй аллага хүртэл хүмүүс амьд тодорхой бие хүмүүс байсан баримт, алагдагсадын урьдын оршихуйг ч ул мөргүй устгаж ард нь үлдэгсэдийн ой ухаанаас арилгаж байсан, үхэл бол тодорхой хүн амьд байж аж төрсөн амьдралын төгсгөл бөгөөд гэтэл тоталитаризмын концлагериуд олон

сая хүн урьд нь амьд байсан баримтыг устгаснаар “үхэл” гэсэн үзэгдлийн өөрийнх нь имманент утга агуулгыг устгасан, гэтэл хүн төрлөхтөний түүхэнд оршин байсан хатуу хахир дэглэм, дарангуй төр засгууд цаазлагдагсадын цогцосыг төрөл төрөгсөдөд нь өгч оршуулах, амьд бие хүн байсныг нь дурсаж санах боломж олгож байсан гэж Х.Арендт бичжээ (6,586).

Чухам ийм учраас хүн төрөлхтөн тоталитаризмын түүхэн гашуун сургамж, сануулгыг байнга санан дурсах, дахин үүсэх, тогтож ноёрхох боломжит аюулаас үргэлж сэрэмжлэх ёстой ажээ. Манай орны улс төрийн түүхийн тодорхой үед тоталитар дэглэм тогтон ноёрхож, монголын цөөн тооны хүн амтай харьцуулахад багагүй тооны хүн ардыг гэмгүй хир нь гэмтэй болгож хорьсон, алж устгасан нийгэм-улс төрийн гэмт хэрэг, түүхэн үзэгдлийг судлах, тэр дотор философи, нийгмийн сэтгэл зүй, улс төрийн ба нийгэм-соёлын антропологийн үүднээс судлан боловсруулахад Х.Арендтын үзэл баримтлал, судалгааны туршлага онол-арга зүйн чухал ач холбогдолтой байх болно.

Abstract

The article deals with the philosophical ideas H. Arendt and existence of prisoners in concentration camps under the domination totalitarian dictatorships in Nazi Germany and the Soviet Union 1930s. The question analyzed in the main work H. Arendt "The origins of totalitarianism" and at the political philosophy aspect. The article detailed by ideas and conclusions of thinker about the features existence of mass human, suffering and pain prisoners, their brutal torture, that systematically carried out in the Nazi prisons.

Ашигласан ном зохиол

Нэг. Монгол хэлээр

1. Гомбосүрэн Ц. Философи. Сурах бичиг. Редактор М.Отгонбаяр. УБ., 2008. – 496 тал.
2. Дарьхүү Р, Содномгомбо Д. Философи. Сурах бичиг. Редактор Г.Чулуунбаатар.УБ., 2004
3. Жан-Поль Сартр. Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн. Эрхлэн хэвлүүлсэн Г.Сайнхишиг. УБ., 2008. – 68 тал.
4. Философи.Сурах бичиг. Редактор Ц. Гомбосүрэн, М.Отгонбаяр. УБ., 2002. – 374 тал.
5. Жаргал Ж. Тоталитаризмын үүслийн талаархи Ханна Арэндтын үзэл баримтлалын тухайд. – Философи, эрх зүйн судлал. XXII боть.УБ., 2007, 246- 252 дахь талд.

Хоёр. Гадаад хэлээр

6. Арэндт Х. Истоки тоталитаризма. Перевод с английского. М., 1996. - 670с.
7. Арэндт Х. Vita activa, или О деятельной жизни / Пер. с нем. и англ. В.В. Бибихина. — СПб., Алетейя, 2000.
8. Ася Энтова. Уроки Ханны Арэндт. "Новости недели", 20.08.1999.
9. Бутенко А.П. От коммунистического тоталитаризма к формированию открытого общества в России (политические и правовые проблемы). М., 1997. – 48 с.
10. Владимир Гячче. Тоталитаризм: позорная история дutoй концепции. Взято с <http://www.rebellion.org/noticia.php?id=27219>.
11. Всемирная история. Учебник для вузов / Под ред. Г.Б. Поляка, А.Н. Марковой. М., 2000. – 742 с.
12. Кравченко С.А. Социологический энциклопедический русско-английский словарь. М., 2004. – 511 с.
13. Новейший словарь иностранных слов и выражений. М., 2002. – 976 с.
14. Современная западная социология: Словарь. Под ред. Ю.Н. Давыдов, М.С. Ковалева, А.Ф. Филиппов. М., 1990. – 432 с.
15. Современная западная философия: Словарь. Под ред. В.С. Малахов, В.П.Филатов. М.,1991.- 414 с.
16. Тоталитаризм. Из истории идеологий, движений, режимов и их преодоления / Руководитель авторского коллектива Я.С. Драбкин, Н.П. Комолова. М., 1996.– 540 с.
17. Хевеши М.А. Массовое общество в XX веке. Соц ис. - 2001.- №7.
18. Хейфец М.Р. Ханна Арэндт судит XX век. М., Иерусалим: ДААТ/Знание, 2003.
19. Шляпентох В.Э. Советский союз – нормальное тоталитарное общество. Соц ис. 2000.- № 2. – с. 115 – 124
20. [Hannah Arendt \(1906-1975\) at the Internet Encyclopedia of Philosophy.](#)
21. [Hannah Arendt \(1906-1975\) at the Stanford Encyclopedia of Philosophy.](#)
22. [Hannah Arendt \(1906-1975\). By Stephen J. Whitfield. Jewis virtual library.](#)